



Бурхан бол итгэмжит Залбирлын Хуудас

Огноо:

- Залбирлын хуудсыг хүн бүрт хувилж өгнө
- Цагтаа эхэлж, цагтаа дуусгана
- Хэрэгтэй зүйлс: Библи, *Ээжүүд Хамтдаа Залбирах нь Товхимол*, үзэг.

♥ **Магтаал** — Бурханыг **Хэн болохынх нь** төлөө, Түүний мөн чанар, Түүний нэр эсвэл Түүний зан чанарынх нь төлөө магтана. Энэ мөчид залбирлын хариулт болон залбирлын хүсэлтүүдээ хэлэхгүй.

Мөн чанар: Бурхан бол итгэмжит

Attribute: God Is Faithful

Тодорхойлолт: Найдвартай, түүштай, үнэнч, гуйвшгүй, тогтвортой, итгэж найдаж болох Нэгэн

Эшлэл(үүд):

- **Дуулал 33:4** Учир нь, ЭЗЭНий үг зөв шударга агаад Бүх бүтээл нь итгэлтэйгээр хийгдсэн буюу.
- **Дуулал 145:13** Хаанчлал тань мөнхийн хаанчлал бөгөөд Ноёрхол тань үеийн үед байна.
- **Гашуудал 3:22-24** ЭЗЭНий хайр энэрэл дуусдаггүй Өршөөл юунд нь төгсгөл үгүй. Өглөө бүр энэ нь цоо шинэ. Таны итгэлт байдал юутай аугаа вэ. “ЭЗЭН миний хувь” гэж Амин сэтгэлээсээ Би өгүүлдэг “Түүнд л хамаг найдлага минь буй.”

♥ **Гэмшил** — Уучилж өршөөдөг Бурханд хандан гэм нүглээ чимээгүй улайх.

Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ. 1 Иохан 1:9

♥ **Талархал** — **Хийсэн зүйлийх нь** төлөө Бурханд талархах. Энэ цагт залбирлын хүсэлтээ хэлэхгүй байх хэрэгтэй. *Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн. 1 Тесалоник 5:18*

♥ **Зуучлан залбирал** — Бурханы өмнө ирж бусдын төлөө залбирах. Хоёр буюу гурваар бүлэгт хуваагдана.

Өөрсдийн хүүхдүүдийн төлөө — Ээж бүр нэг хүүхэд сонгоно. (Библийн ишлэлээр залбирах/Залбирлын тодорхой хүсэлт)

Эшлэл(үүд): 1 Коринт 10:13

Библийн эшлэлээр залбирах:

(Хүүхдийн нэр)-д учирсан сорилт нь хүнд тохиолддог л зүйл гэдгийг Та түүнд мэдүүлээч. Харин Бурхан Та итгэмжтэй бөгөөд (Хүүхдийн нэр)-ийг хэрээс нь хэтэртэл соригдохыг зөвшөөрдөггүй, харин (Хүүхдийн нэр) дааж гарахын тулд сорилттой хамт мөн гарцыг ч (Хүүхдийн нэр)-д буй болгоно.

Залбирлын тодорхой хүсэлт

Багш/Ажилчид (нэгийг сонгоно): Багш/Ажилтаны төлөө залбирах нэг эшлэл сонго. Дараа нь тодорхой нэг хүсэлтийн дагуу залбирна.

- Эзэн минь ээ Та _____-ний нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэд Таньд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно. *Үйлс 26:18*
- _____-д учирсан сорилт нь хүнд тохиолддог л зүйл гэдгийг Та түүнд мэдүүлээч. Харин Бурхан Та итгэмжтэй бөгөөд _____-ийг хэрээс нь хэтэртэл соригдохыг зөвшөөрдөггүй, харин _____ дааж гарахын тулд сорилттой хамт мөн гарцыг ч _____-д буй болгоно. *1 Коринт 10:13*

Сургуулийн төлөө залбирах – Сургуулийн орчинд сэргэлт ирж, сүнсний хараа өгөгдөхийн төлөө (цаг байвал хамгаалалт гэх мэт өөр бусад сэдвүүдийн төлөө)

Ээжүүд Хамтдаа Залбирах нь үйлчлэлийн төлөө залбирах — Сургууль бүрийг залбирлаар хучих; үйлчлэлийг хамгаалж өө сэвгүй, цэвэр ариунаар хадгалах.

Бүлэгт залбирсан бүхэн зөвхөн бүлэг дотроо л үлдэх ёстойг анхаараарай!